



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 02-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2018 оны 11 сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн “Дүрэм”-ийн 7 дугаар зүйлд дор дурдсан нэмэлтийг оруулсугай. Үүнд:  
**7.1.7.6 Компани хараат болон охин компанийн хэлбэрээр банк бус санхүүгийн байгууллагыг шинээр үүсгэн байгуулах, үүсгэн байгуулагчаар оролцох, дангаар болон хамтран хөрөнгө оруулах, хараат болон охин компанийн хувьцааг худалдан авах, худалдах, оруулсан хөрөнгөө эргүүлэн татах, татан буулгах, толгой компанид нэгтгэх эрхтэй.**
2. Дүрэмд оруулсан нэмэлтийг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. “Материалимпэкс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Компанийн дүрэм”-ийн бусад зүйл, заалтыг хэвээр үлдээсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Г.АЮУШМАА



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 02-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## “МАТЕРИАЛ КРЕДИТ” ХХК ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 14-16 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15 дахь хэсэг, 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материал кредит” гэсэн оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу “ХХК”-ийг үүсгэн байгуулсугай.
2. “Материал кредит” ХХК /цаашид “Компани” гэнэ/-ийн оршин байх газар буюу хууль ёсны хаяг нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, Нарны зам 16/5 /16010/, “Материалимпэкс” ХК-ийн байр, А корпус, 105 тоот байхаар тогтоосугай.
3. Компанийг үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1 000 000 /Нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг энгийн хувьцаа гаргахаар тогтоосугай.
4. Компани нь хугацаагүйгээр дараах үйл ажиллагаа эрхлэн явуулсугай. Үүнд:
  - 4.1. Гадаад худалдаа
5. “Компанийн дүрэм”-ийг 1 дүгээр Хавсралтаар баталсугай.
6. Компанийн гүйцэтгэх захирлаар Дагва овогтой Оюуныг томилж, гэрээ байгуулсугай.

### ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

№	Үүсгэн байгуулагч хувь хүн, хуулийн этгээд	Гарын үсэг, тэмдэг	Үүсгэн байгуулагчийг төлөөлж:
1.	"Материал импэкс" ХК	.....	Гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч Б.Зориг
		.....	Хувьцаа эзэмшигч Д.Тунгалаг
		.....	Хувьцаа эзэмшигч Г.Аюушмаа
		.....	Хувьцаа эзэмшигч Д.Оюун
		.....	Хувьцаа эзэмшигч Б.Ганболд

		.....	Хувьцаа эзэмшигч Г.Мягмардорж
		.....	Хувьцаа эзэмшигч А.Чулуун
		.....	Хувьцаа эзэмшигч Д.Даваадорж
		.....	Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн
		.....	Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг

ХУРЛЫН ДАРГА

Г.АЮУШМАА